

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛЭЭС


ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ЯАМАНД

Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 8 дугаар сарын 31-ний өдрийн хуралдааны 38 дугаар тэмдэглэлд:

“ҮИИ.ХЭЛЭЛЦСЭН нь: Бусад асуудал

ШИЙДВЭРЛЭСЭН нь: 1. Монгол Улсын эдийн засаг, нийгмийн хөгжилд хувь нэмэр оруулж 2016 оны үйл ажиллагааны үр дүнгээр ТОП-100 аж ахуйн нэгжийн жагсаалтад эхний 10-т орсон хуулийн этгээдийн ерөнхий захирал болон түүний эхнэр(нөхөр)-т албан паспорт олгох нь зүйтэй гэж үзэв.

2. Өмнөговь аймгийн Ханбогд сумын Цагаан хад дахь гаалийн хяналтын бүсийг цаашид ажиллуулах шаардлагатай эсэх асуудлыг судалж, уг бүс нутгийг хөгжүүлэх, иргэдийн ажиллаж, амьдрах нөхцөлийг бүрдүүлэх талаар санал боловсруулах үүрэг бүхий хамтарсан Ажлын хэсгийг байгуулан ажиллуулж, холбогдох саналаа 2017 оны 10 дугаар сард багтаан Засгийн газарт танилцуулахыг Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Д.Оюунхорол, Зам, тээврийн хөгжлийн сайд Д.Ганбат, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Ц.Дашдорж, Сангийн сайд Б.Чойжилсүрэн, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Ж.Мөнхбат нарт даалгав.” гэжээ.



ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР